

II.МОНГОЛ УЛСЫН ОРШИН ТОГТНОХЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

20.Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал хангагдсаныг хэлнэ.

21.Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад сорог нолоолж болох гадаад хүчин зүйлүүд:

1/ аливаа улс, хүчин Монгол Улсын эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдэх буюу үйлдэхээр заналхийлэх;

2/ Монгол Улсын торийн тусгаар тогтнолыг хүчээр оорчлох, ард түмний үндэсний эв нэгдлийг сарниулах бодлого явуулах;

3/ олон улсын эрх зүйн дагуу бусад улстай чолоотэй харьцахад саад хийх, дарамт шахалт үзүүлэх;

4/ Монгол Улс, түмний ард иргэдийн эсрэг алан хядах, хорлон сүйтгэх, тагнан турших үйл ажиллагаа явуулах, зохион байгуулах буюу тийнхүү үйл ажиллагаа явуулахыг одоон турхирах, туслах;

5/ аливаа улс бүрэн оорийн ашиг сонирхол, үзэл бодлыг Монгол Улсад хүчээр тулгах, маргааныг хүч хэрэглэх замаар шийдвэрлэхийг оролдох;

6/ Монгол Улсыг улс тор, цэрэг, эдийн засаг, үзэл бодлын хувьд эрхшээлдээ оруулах;

7/ дэлхий дахин, бvс нутаг буюу салбар бvс нутагт манай улс оронд нолоолохвйц зорчил хямрал vвсч дайнд татагдан орох;

8/ Монгол Улсын эдийн засгийг тогтворгвй болгох, торийн эргэлт гаргуулахаар завдах буюу хийх, бусад улс орны эсрэг бодлого, вйл ажиллагаандаа тvшиц болгон ашиглах;

9/ улсын хилийг оорчлох, хууль бусаар хил нэвтрэх, хилийн зорчил гаргах;

10/ хил залгаа орнуудын хоорондын зорчил тэмцэл, морголдоонд татагдан орох, тэдгээрийн дотоод зорчил, хямралын уршигт нэрвэгдэх;

11/ хорш орноос дvрвэгсэд олноор орж ирэх;

12/ байгаль, экологийн гай гамшиг гарах, хvн ба амьтны гоц халдварт овчин гарч тархах.

22.Монгол Улсын оршин тогтнохын аюулгвй байдлыг хангахад сорог нолоолж болох дотоод хvчин зvйлvвд:

1/ торт ёс алдагдах, Монгол Улсыг бусад улсад дагаар оруулах явуулга, оролдлого хийх;

2/ vндэсний эв нэгдлийг сарниулах, Монгол Улсын тусгаар тогтносон байдлыг алдагдуулах улс тор, эдийн засаг, цэргийн бодлого явуулах;

3/ шашин, vндэс угсаа, нутаг орны хурц маргаан, зоролдоон гарах нохцол байдал бий болох;

4/ Монгол Улсын хvчин чадлыг сулруулах, хорлон сvйтгэх, тагнан турших ажиллагаа явуулах;

5/ зэвсэгт хвчин, бусад цэрэг дотроо хуваагдах, тvvний байлдах чадвар, цэрэг-эх оронч вээл алдагдах, цэрэг-иргэний талцал маргаан, зэвсэгт вймээн, морголдоон гарах.

23. Монгол Улсын оршин тогтнохын аюулгвй байдлыг хангах арга зам:

Нэг.1/ аливаа улстай харилцахдаа орчин veийн олон улсын эрх зvйн тvгээмэл зарчмуудыг сахих, бусдаар сахиулах;

2/ олон улсын энх тайван, аюулгвй байдлыг бэхжvвлэхэд чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын бусад байгууллагын вйл ажиллагааг дэмжиж, нягт хамтран ажиллах;

3/ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дvрмийн 51 дvгээр зvйлийн дагуу улс орноо тvрэмгийллээс дангаараа буюу хамтын хвчээр хамгаалах эрх зvйн вндсийг хоёр болон олон талын шугамаар бvрдvвлэн баталгаажуулах;

4/ Ази, Номхон далайн бvс нутаг, ялангуяа Зvнн-хойд Ази, Тов Азид стратегийн тогтвортой байдлыг хангах, энх тайвныг бэхжvвлэх, аюулгвй байдлын найдвартай тогтолцоог бий болгох бодлого явуулах;

5/ нутаг дэвсгэрээ бусад улс орны эсрэг ашиглуулахгвй байх бодлогыг тууштай баримтлах, Монгол Улсын цомийн зэвсэггвй бvсийн статусыг олон улсын хэмжээнд баталгаажуулж, аюулгвй байдлаа улс торийн аргаар бэхжvвлэх чухал тулгуур болгох. Тов Азийг цомийн зэвсэггвй бvс болгох чиг баримтлах;

6/ Монгол Улсын вндэсний язгуур ашиг сонирхлыг хондсон, тvvнд харшилсан болон Монгол Улсын нэр хvндийг гутаахад чиглэсэн аливаа явууллагад цаг тухайд нь вндэслэл бvхий няцаалт огч, шаардлагатай гэж взвэл торийн бодлого, вйл ажиллагаандаа зохих ёсоор тусгаж байх;

7/ гадаад улс оронтой харилцах нэг чухал суваг болох "ардын дипломат" бодлогыг оргоноор ашиглаж Монгол Улсыг мэддэг, дэмждэг уур амьсгалыг бусад улс оронд, нэн ялангуяа хорш зэргэлдээ болон нолоо бvхий улс оронд буй болгох;

8/ Монгол Улсад оршин суух гадаадын иргэд, харьяалалгвй хvмvвсийн тоо, тэдний зорчин явах журмыг хуульчлан тогтоож, хяналт тавих, Монгол Улсад хууль бусаар оршин суух явдлыг гаргуулахгвй байх хяналтын тогтолцоотой болох.

Хоёр. 1/ Монгол Улс бусад улс орон, олон улсын байгууллагуудтай цэргийн салбарт хамтран ажиллаж, оорийгоо болзошгвй тvрэмгийллээс урьдчилан сэргийлэх, хамтын хvчээр батлан хамгаалах бодлогодоо хорш зэргэлдээ, гурав дахь улс гvрэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын бусад нэгдсэн зэвсэгт хvчнийг ашиглах чиг баримтлах;

2/ улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бvрэн бvтэн байдал, улсын хилийн халдашгвй дархан байдлыг хамгаалах чадвартай vндэсний зэвсэгт хvчин, бусад цэрэгтэй байх;

3/ Монгол Улс оорийгоо батлан хамгаалах зорилтоо бvх нийтийн батлан хамгаалах тогтолцоонд тулгуурлан оорийгоо хамгаалах цэргийн номлолын дагуу хэрэгжvвлэх.Тvрэмгийлэл, зэвсэгт халдлагаас гагцхvв оорийн хvчинд тулгуурлан хамгаалахад хvрвэл оорийгоо хамгаалах дайн явуулж, тvвнд дотоодод байгаа бvх хvч арга хэрэгсэл, гадаад хvчин зvйлийг оргоноор ашиглах;

4/ цэргийн салбарт итгэлцлийг бэхжvвлэх, бvс нутгийн аюулгвй байдлыг хангах механизм буй болгох олон улсын хvчин чармайлт, хамтын ажиллагаанд боллоцооныхоо хэрээр оролцох.